

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн /13/ дугаар албан бичгийн хавсралт

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх баримт бичиг

Нэг. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.9, Ахмад настны тухай хуулийн 7.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 сарын 14-ний өдрийн А/65 дугаар тушаалд заасны дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын баримт бичиг, үйлчилгээ үзүүлэх байр, иргэдэд үзүүлэх үйлчилгээ нь мэргэжлийн болон чанарын шалгуур хангаж байгаа эсэхийг үнэлэхэд оршино.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөл хэрэгжүүлэх ба уг зөвлөлийн шийдвэрийг үндэслэн нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр магадлан итгэмжлэлийг олгоно.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдаж, нээлттэй, ил тод, бусдын нөлөөнд үл автах, шударга байх зарчимд тулгуурлана.

Хоёр. Магадлан итгэмжлэл авах хүсэлт гаргаж буй байгууллага, иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

- 2.1. Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр нэг ба түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
- 2.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.6, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-7.1.4-д заасан үйлчилгээний төрлүүдээс үзүүлдэг байх;
- 2.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан, зориулалтын байртай байх;
- 2.4. Тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд заагдсан үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн боловсон хүчинтэй байх;
- 2.5. Татвар, нийгмийн даатгалын байгууллагад өргүй байх;
- 2.6. Төрийн бус байгууллагын хувьд магадлан итгэмжлэлд орох асуудлыг хамт олноороо хүлээн зөвшөөрсөн тодорхойлолттой байх;
- 2.7. Жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байх;
- 2.8. Бүрдүүлсэн баримт бичгүүд үнэн, бодитой байх;
- 2.9. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавих шалгуур үзүүлэлт, журам, стандартыг хангасан байх;
- 2.10. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заагдсан ажлын байрандаа сүүлийн нэг жилийн дотор үйл ажиллагаа явуулсан байх;
- 2.11. Сүүлийн 2 жилийн хугацаанд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон бол оролцох эрхгүй.

Гурав. Магадлан итгэмжлэл авах хүсэлт гаргах байгууллага, иргэн нь дор дурдсан материалыг бүрдүүлнэ.




- 3.1 Байгууллагын танилцуулгад дараах агуулгыг бүрэн багтаасан байна.
 - 3.1.1. Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны талаарх товч танилцуулга, үйлчилгээ үзүүлэх байрны фото зураг;
 - 3.1.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настанд үзүүлэх үйлчилгээний аль төрлийн үйлчилгээг үзүүлэх тухай;
 - 3.1.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хувьд аль зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээг үзүүлэх тухай;
 - 3.1.4. Үйлчилгээг аль аймаг, дүүрэгт үзүүлэх тухай;
 - 3.1.5. Үйлчилгээ авах иргэдийн хэрэгцээний судалгаа;
 - 3.1.6. Үйлчилгээнд шаардагдах багаж, байр, орон сууцны үзүүлэлт, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн тодорхойлолт, жагсаалтыг гарган, фото зургийн хамт хавсарган ирүүлэх;
- 3.2. Үйлчилгээ үзүүлэх байгууллагын санал болгож буй удирдах болон мэргэжлийн боловсон хүчний боловсрол, ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг нотлох баримт бичгийн хамтаар ирүүлэх;
- 3.3. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт бүхий албан бичиг;
- 3.4. Байгууллагын болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 3.5. Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар /анх удаа орох байгууллагад хамаарахгүй/;
- 3.6. Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтээр хийсэн өөрийн үнэлгээний тайлан;
- 3.7. Сүүлийн 2 жилийн хугацаанд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настанд үзүүлэх үйлчилгээний ижил төстэй үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан тохиолдолд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайлан мэдээлэл; /давтан магадлан итгэмжлэл авах байгууллага бол магадлан итгэмжлэгдсэн хугацааны, харин анх удаа магадлан итгэмжлэл авах байгууллага бол сүүлийн 1 жилийн үзүүлэлт/
- 3.8. Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;
- 3.9. Санхүүгийн баталгаажсан тайлан;
- 3.10. Харилцагч банкны тодорхойлт (Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй харилцагч банк бүрээс хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлт авч ирүүлэх);
- 3.11. Магадлан итгэмжлэлд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь баримт бичгийг бэлтгэн цаасан хэлбэрээр ирүүлнэ.
- 3.12. Магадлан итгэмжлэлийн баримт бичгийн бүрдүүлэлтэд заасан материалуудаас аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын материалаас татгалзах үндэслэл болно;
- 3.13. Магадлан итгэмжлүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг буцаан олгохгүй.

Дөрөв. Материал ирүүлэх хугацаа

Магадлан итгэмжлэх хүсэлтэй байгууллага нь материалыг ирүүлэхдээ 2 хувь хийх ба хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

Баримт бичгийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр ирүүлэх бөгөөд хувиудыг тус тусад нь "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР ХУВЬ" гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж, тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд хийж ирүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэх байр, орчны нөхцөл байдал, ажлын байртай газар дээр нь очиж танилцах зардлыг оролцогч байгууллага өөрөө хариуцна. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна.



Үүнд:

(а) Магадлан итгэмжлэх хүсэлт гаргасан байгууллагын хаяг:

Албан ёсны нэр, хаягтай байх; (Байгууллагын нэрийг товчилж бичихгүй, аймаг, дүүргийн нэр, байгууллагын тэргүүн, холбоо барих утас)

(б) Баримт бичиг хүлээн авагч: "ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР", "НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗАР"-т гэж хаяглана.

(в) Баримт бичиг хүлээн аван эцсийн хугацаа:

Баримт бичгийг 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 17:00 цагаас өмнө ирүүлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дор дурдсан хаягаар хандан авч болно.

Хаяг: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар,

Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Хөдөлмөрийн ордон, 109 тоот, утас-70147020